“ДЦС-3” ТӨХК-ИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2018 он

ЭРХЭМ ЗОРИЛГО

Эх орноо хөгжилд хөтлөх эрчим хүчийг бүтээнэ

ХЭТИЙН ЗОРИЛГО

2021 онд хүний хөгжлийг дээдэлсэн , байгаль орчинд ээлтэй, дэлхийн жишигт хүрсэн компани болно.

СТАНЦЫН ТАНИЛЦУУЛГА

1966 он
Анхны суурь тавигдсан

1966-1968 он
ПТ-12-35/10 турбин – 4ш
БКЗ-75-39 зуух – 6ш
48 МВт

1976-1981 он
ПТ-25-90/10 турбин – 4ш
БКЗ-220-100 зуух – 7ш
100 МВт

2013-2014 он
С50-8,83/0,294 турбин
50 МВт

198 МВт

Тус станц ТЭХС-ийн цахилгаан хэрэглээний 17,5%, Улаанбаатар хотын дулаан хангамжийн 34,8%, үйлдвэрийн технологийн уурын хэрэглээний 80 гаруй хувийг ханган ажиллаж байна.

СТАНЦЫН ТАНИЛЦУУЛГА

ТҮҮХЭН ТОВЧОО

Дулааны 3-р цахилгаан станцын суурь 1966 оны 12-р сарын 3-нд тавигдаж, 1968 оны 12-р сарын 10-нд анхны зуух ашиглалтанд орж нийслэл хотын үйлдвэр, албан байгууллага, ард иргэдэд дулааны эрчим хүчийг түгээж эхэлсэн манай цахилгаан станц өндөр ба дунд даралтын гэсэн 2 станцаас бүрддэг бөгөөд дунд даралтын станц 48 меговатт, Өндөр даралтын станц 100 меговатт цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх суурилагдсан хүчин чадалтай.

Дунд даралтын хэсэг нь1966-1975 онуудад баригдаж цагт 40 атмосферийн даралттай 75 тонн уур боловсруулах чадалтай БКЗ-75-39 фБ загварын 6 уурын генератор, цагт 12мвт цахилгаан боловсруулах чадал бүхий Пт-12-35/10м загварын 4 турбогенератор болон тэдгээрт холбогдох төрөл бүрийн туслах тоноглол, тоног төхөөрөмжүүдийн хамтаар угсрагдан тавигдсан.

Өндөр даралтын хэсэг нь 1976-1980 онуудад баригдаж цагт 100 атмосферийн даралттай 220 тонн уур боловсруулах чадалтай БКЗ-220-100 4с загварын 7 уурын генератор, цагт 25мвт цахилгаан боловсруулах чадал бүхий Пт-25-90-10м загварын 4 турбогенераторыг тус, тусын туслах тоноглол, тоног төхөөрөмжүүдийн хамтаар угсран ашиглаж эхэлсэн.

СТАНЦЫН ТАНИЛЦУУЛГА

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тус цахилгаан станц нь 6 киловольтын хүчдэлийн түвшинтэй 50гц давтамжтай хувьсах цахилгаан эрчим хүчийг боловсруулж, 6 киловольт хүчдэлийг 35/110 киловольтын түвшинд өсгөж агаарын шугамаар эрчим хүчний нэгдсэн системтэй холбогдон монгол улсын цахилгаан эрчим хүчний хэрэглээний 17 гаруй хувь, улаанбаатар хотын дулааны эрчим хүчний хэрэглээний 32 хувийг уур усаар түгээж технологийн уур хэрэглэдэг 60 гаруй компаниудыг үйлдвэрийн технологийн хэрэгцээний уураар хангадаг.

СТАНЦЫН ТАНИЛЦУУЛГА

Бүтэц зохион байгуулалтын хувьд тус компани нь: 3 алба, 7 хэлтэс, 4 хэсэг, 2 лаборатори болон 10 цехээс бүрдэх бөгөөд нийт 996 ажиллагсадтай. Ажиллагсадын 65 гаруй хувь нь 35 хүртлэх насны залуучууд ба нийт ажиллагсадын 45 хувь нь дээд, тусгай дунд боловсролтой.



ХИМИ ЦЕХ

Хими цех нь техник ашиглалтын дүрмийн шаардлага хангасан давсгүйжүүлсэн усаар станцыг тасралтгүй хангаж уур-усны чанарын нормыг хангуулах үүрэгтэй. Бүрэн давсгүйжүүлсэн усыг боловсруулахдаа орчин үеийн дэвшилтэт технологи болох эсрэг Осмосын аргаар усыг боловсруулж байна.

“ДЦС-3” ТӨХК-ний Химийн төв лаборатор

- ***Химийн төв лабораторын үндсэн зорилго нь***: Станцын үндсэн ба туслах тоноглолуудын уур-усны химийн горимын хяналтын бүх үйл ажиллагааг гүйцэтгэх, тоноглолын их засварын үед химийн горим талаас үзлэг хийж горим барилтанд үнэлгээ өгөх, халах гадаргуугийн хоолойноос хяналтын огтлолын дээж авч тогтсон хаг хурдсанд химийн найрлагын шинжилгээг гүйцэтгэж дүгнэлт гаргах, түлш, тос, тоосон нүүрс, дутуу шаталтын чанарын шинжилгээг хийж тоноглолын найдвартай ажиллагааг хангуулах юм. Одоо химийн төв лаборатори нь 8-н ажиллагсадтай шинжилгээний сүүлийн үеийн багаж, тоног төхөөрөмжүүдээр тоноглогдсон уусмал бэлтгэх өрөө, уур-ус, түлш, тоосон нүүрс дутуу шаталт, тос, калориметрийн лаборатори гэсэн орчин үеийн лабораторийн түвшинд хүрсэн ажлын байруудаар хангагдсан

Түлшний шинжилгээний лаборатори: Тус лабораторит түлшний техник анализын шинжилгээнүүдийг хийж байна. Түлшний чийглэг, үнслэг, дэгдэмхий бодисын хэмжээ болон дулаан гаргах чадварыг стандартын дагуу тодорхойлж байна. Мөн мазутын чийглэг, дулаан гаргах чадварыг тодорхойлдог.

Уур-усны лаборатори: Тус лабораторид усны болон хаг хурдсын шинжилгээний 180 төрлийн шинжилгээний уусмалыг стандартын дагуу бэлтгэх ба станцын үүсгэвэр ус, үнсэн сангийн ус, өндөр ба дунд даралтын станцын үндсэн ба туслах тоноглолуудын уур-усны химийн горимын хяналтын бүрэн ба хураангуй шинжилгээг хийнэ. Уур-усны химийн хяналт нь эрчим хүчний тоног төхөөрөмж, байгууламжийн техник ашиглалтын дүрэмд нормчлогдсон 34 үзүүлэлтүүдийг хангуулан ажиллах, түүнд хяналт тавихад чиглэгддэг.

Тоосон нүүрс, дутуу шаталтын шинжилгээний лаборатори: **Тоосон нүүрс, дутуу шаталтын шинжилгээний лабораторит зуухны шаталтын горим ажиллагааг илэрхийлсэн тоосон нүүрсний нунтагралтын хэмжээ, чийг агуулалт, шаталтын дараа шлак ба үнсэн дэхь дутуу шаталтын хэмжээг тодорхойлдог.**

Тосны шинжилгээний лаборатори: **Тосны лабораторид турбогенератор, зуух болон түүний туслах тоноглолуудын тосолгооны тосонд батлагдсан хуваарийн дагуу бүрэн болон хураангуй шинжилгээг стандартын дагуу хийнэ. Мөн станцад шинээр ирж буй тосолгооны материалуудын чанарын шинжилгээг хийдэг.**

Ажил олгогчийн ажлын байранд тавигдах ерөнхий ба тусгай шаардлага хэрэгцээний талаар

Эрчим хүчний салбарын химийн мэргэжилтнүүдэд тавигдах шаардлага нь станцын дотоод циклийн уур-усны чанарын нормыг мөрдүүлэхэд дулаан техникийн ойлголт буюу термодинамикийн суурь ойлголтыг маш сайн эзэмшсэн байх ерөнхий шаардлага тавигддаг.

Сүүлийн үеийн төгсөгчдийг шинжилгээний чанар хангалтын талаар хэмжилзүйн нэр тодорхойлолтуудын ойлголттой төгсгөвөл ажил олгогчийн хэрэгцээнд нийцэх хандлагатай байна.

АНХААРАЛ ТАВЬСАНД БАЯРЛАЛАА